



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/560

Мандалговь

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоолын 6 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд болох “Байгаль орчин, аялал жуулчлалын газар” гэснийг “Байгаль орчны газар” гэж, “Боловсрол, шинжлэх ухааны газар” гэснийг “Боловсролын газар” гэж, “Соёл, урлагийн газар” гэснийг “Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар” гэж тус тус өөрчилсүгэй.
2. Шинэ бүтэц, чиг үүрэгтэй уялдуулан ажлаа зохион байгуулж, ажиллахыг дээрх байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.
3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/09, 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/92 тоот захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.АНХБАЯР

4824101242